

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ;.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	15
4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	17
4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
4.6. Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	23
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	24

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2020.02.21 № 06/568  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2.Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн захирал М.Даваабат Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох, өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлэх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 3-наас 2020 оны 2 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Энич аудит” ХХК аудитор Б.Гантуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 36 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, мэргэжлийн өвчний мэргэшсэн үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөдөлмөрийн хүний аюулгүй байдал, амьдралын чанарыг алдагдуулахгүй байхын төлөө тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй, чанартай үзүүлж аливаа эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэхэд оршино.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг судлах, эрүүл ахуйн хэмжилт хийх, үнэлгээ, дүгнэлт гаргах
- Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг оношлох, эрт илрүүлэх, эмчлэх, нөхөн сэргээж сувилах
- Хөдөлмөр зохицуулалт, магадлал хийх
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа болон сурталчилгааны ажлыг зохион байгуулах

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөтэй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 24 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

#### **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,115,931.2 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 22,318.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 51,636.0 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 оны жилийн эцсийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн нийт зардлын дүнгээс тооцсонтой холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 154,250.5 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	263,778.6	209,511.3	(54,267.3)
Урьдчилгаа			
Бараа материал	281,407.0	304,910.8	23,503.8
Үндсэн хөрөнгө	2,682,159.8	2,558,772.8	(123,387.0)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,227,345.4</b>	<b>3.073,194.9</b>	<b>(154,150.5)</b>
Өр төлбөр	259,491.0	179,074.6	(80,416.4)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	690,350.4	690.350.4	
Хуримтлагдсан үр дүн	2,277,504.1	2,203,769.9	(73734.2)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,227,345.4</b>	<b>3.073,194.9</b>	<b>(154,150.5)</b>

Авлага дансны үлдэгдэл буурсан нь өмнөх онд үүссэн өр авлагаа төлж, барагдуулснаас шалтгаалсан байна. Авлага дансны үлдэгдэлд 2010-2015 онуудад үүссэн, он удаан жил болсон 25,651.8 мянган төгрөгийн 1 байгууллага, 16 хувь хүнээс авах авлага байна. Үүнээс холбогдох эзэд нь тодорхойгүй, нотлох баримтгүйн улмаас хуулийн байгууллагад хандах боломжгүй эрсдэлтэй 10,826.4 мянган төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь оны эцэст эм, боох материалыг ханган нийлүүлэгч байгууллага гэрээний дагуу нийлүүлснээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд 2008 онд худалдаж авсан ашиглалтгүй, эвдэрсэн, акталж, устгаагүй 138 нэрийн 10,579.1 мянган төгрөгийн хангамжийн бараа материал байна. Энэ нь 2015 оноос хойш бараа материалын чанар байдлыг Өмч хамгаалах комиссоор шийдвэрлүүлж, акталж, устгаагүйгээс шалтгаалан ашиглалтын шаардлага хангахгүй, аж ахуйн материалын үлдэгдэл ихэссэн байна. Оны эцэст 23,503.8 мянган төгрөгийн эм, боох материалын худалдан авалт хийж, бараа материалын нөөц үүсгэсэн нь тендерт шалгарсан ханган нийлүүлэгч байгууллагууд гэрээний үүргийн дагуу нийлүүлэлт хийгдсэнээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 123,387.0 мянган төгрөгөөр буурсан нь 11,160.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг шинээр бэлтгэсэн, 134,547.0 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон дүнгээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 80,416.4 мянган төгрөгөөр буурсан нь 4 аж ахуйн нэгж байгууллагад төлөх өглөгөө барагдуулсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 179,074.6 мянган төгрөгийн өглөг нь 4 аж ахуйн нэгж байгууллагад төлөх данс андуурсан гүйлгээний 1,326.0 мянга, Чингэлтэй дүүргийн Давж

заалдах шатны шүүхийн 2018 оны 2358 дугаар шийдвэртэй 1 аж ахуйн нэгж байгууллагад төлөх 107,577.1 мянга, он дамжсан урьдчилан сэргийлэх үзлэг хийгдэх 8 гэрээт аж ахуйн нэгжид төлөх 70,171.5 мянган төгрөгийн өглөгүүд байна.

## **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ;**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрт зориулан 2,333,549.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,463,506.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 870,043.2 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Улсын төсвөөс 1,463,506.5 мянган төгрөгийн санхүүжилт бүрэн олгогдсон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 870,043.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээс 861,887.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 8,156.6 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар тасарсан, туслах үйл ажиллагааны орлого 150,914.7 мянган төгрөгөөр буюу 88.2 хувиар тасарснаас шалтгаалжээ.

Туслах үйл ажиллагааны орлого 150,914.7 мянган төгрөгөөр тасарсан нь Агаар сувиллын барилга нь Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2014 оны 02-07-90/604 тоот дүгнэлтээр эрүүл ахуйн болон аюулгүйн шаардлагыг хангахгүй тул үйл ажиллагааг зогсоосноос шалтгаалсан байна. Цаашид сувиллыг засварлах, шинээр барилга байгууламж барих талаар холбогдох шатны байгууллагуудад хандсан боловч шийдвэрлэгдээгүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,955,387.9 мянган төгрөг буюу 83.8 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй харьцуулахад нийт дүнгээр 378,161.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулсны 84.8 хувь буюу 320,650.0 мянган төгрөг байрны түрээсийн зардлын хэмнэлттэй холбоотой байна.

Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 333,046.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт төсөв:** Дээд шатны төсвийн захирагчаас 172,000.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 112,917.2 мянга, нийт 284,917.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 95,750.3 мянга, хангамж, бараа материалын зардалд 28,680.0 мянга, норматив зардалд 42,240.6 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 79,547.4 мянга, бараа, үйлчилгээний бусад зардалд 16,887.6 мянга эд хогшил худалдан авахад 17,166.9 мянга, томилолт, зочны зардалд 2,250.0 мянга, урсгал шилжүүлэгт 1,950.0 мянган төгрөг нийт 284,472.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 626.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 5 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж, нийт 9 горим, сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 42,043.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 13,815.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,324.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож,



26,904.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Аудитын явцад цалингийн тооцооллоор нийт 6,887.0 мянга, хувь хүний орлогын албан татварыг тооцож, суутгаагүй 2,115.1 мянга, анхан шатны баримтаар 4,813.5 мянган төгрөгийн 5 ажил гүйлгээг бүртгэсэн нийт 13,815.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залруулсан.

Аудитаар дараах 28,228.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1,324.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1.Дотоод албан томилолтын зардлын анхан шатны баримтын бүрдэл дутуу, өмнөх онд олгогдох дотоод албан томилолтын зардлыг он дамжуулж олгосон, 2018 онд өглөгөөр тусгаагүй 1,324.0 мянган төгрөгийн дотоод албан томилолтын зардлыг илүү тооцож олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;" Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 3 дугаар зүйлийн 3.2-т ..."Төсвийн зардлыг батлагдсан төсөв, зарцуулалтын эрхийн баталгаа, эрх бүхий байгууллагын шийдвэр, гэрээг үндэслэж гарсан зардлыг анхан шатны баримтыг үндэслэн хүлээн зөвшөөрч бүртгэнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй, Сангийн сайдын 2018 оны 301 дүгээр тушаалаар батлагдсан журмыг мөрдөж ажиллаагүй үнэн зөв байдал, хэмжилт, тохиолдсон байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### Шийдвэрлэсэн нь

Төлбөрийн акт тогтоох

### **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлангийн явцад цаашид анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

### **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 38 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

### **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 35,543.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснээс 9,891.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгаж, 2010-2015 онд үүссэн 17 харилцагчаас авах 31,651.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулахаас 1 харилцагчийн 6,000.0 мянган төгрөгийг барагдуулж, үлдэх 25651.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, албан шаардлагын хэрэгжилт 12.3 хувь байна.

Нийт 1 зөвлөмж өгснөөс хэрэгжилт 100 хувьтай байна.

### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 28,228.3 мянган төгрөгийн алдаа зөрчил нь бидний тооцсон 51,636.0 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өглөө.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дах заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### *1. Балансын данстай холбоотой асуудал*

##### 1.1 Илрүүлэлт:

Ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засвар хийх боломжгүй, сэлбэг нь үйлдвэрлэгдэхээ больсон зэрэг нийт 136 нэрийн анхны өртгөө нөхсөн ашиглалтын шаардлага хангахгүй болсон хөрөнгүүдийг акталж, устгах талаар арга хэмжээ авч, холбогдох шатны байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4.1 дэх заалт "эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд "Төрийн байгууллага, албан газар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй: 1-д "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах; гэсэн заалтуудтай нийцэхгүй, үнэн зөв байдал, хэмжилт, тохиолдсон байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

##### 1.2 Эрсдэл:

Төрийн өмчид бүртгэлээр тавих хяналт сулрах, санхүүгийн үр дүнд нөлөөлөх

##### 1.3 Өгсөн зөвлөмж:

Нийт 136 нэрийн анхны өртгөө нөхсөн ашиглалтын шаардлага хангахгүй болсон 145,394.4 мянган төгрөгийн хөрөнгүүдийг акталж, устгах, шинээр бэлтгэх талаар арга хэмжээ авч, холбогдох шатны байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

##### 1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчлийг байгууллагын дарга, нягтлан бодогч нар хүлээн зөвшөөрсөн болно.

## *2. Балансын данстай холбоотой асуудал*

### 2.1 Илрүүлэлт:

Өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй, 2010-2015 онд үүссэн 17 харилцагчийн 25,651.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй, үнэлгээ, үнэн зөв байдал, эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### 2.2 Эрсдэл:

Өр, авлагын дүн буурахгүй байх, бүртгэлээр тавих хяналт сулрах.

### 2.3 Өгсөн зөвлөмж:

Аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах, авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах

### 2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчлийг байгууллагын дарга, нягтлан бодогч нар хүлээн зөвшөөрсөн болно.

## *3. Зардлын данстай холбоотой асуудал*

### 3.1 Илрүүлэлт:

Хот дотор ажил, үйлчилгээнд хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж нь 2500 см<sup>3</sup>-ээс дээш, туулах чадвар өндөртэй, шатахуун их зарцуулдаг автомашин ашиглаж, 2019 онд нийт 1,252.5 мянган төгрөгийн шатахууныг хэтрүүлэн зарцуулсан нь Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 184 дүгээр "Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоол"-ын 2-т "Албан тушаалын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашиныг хотын дотор хуанлийн хоног (баярын болон долоо хоногийн амралтын өдрийг оролцуулан)-т дунджаар 70 км, албан ажлын хэрэгцээний автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашиныг хотын дотор ажлын хоногт дунджаар 50 км, дуудлагын автомашины хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж 2500 см<sup>3</sup>-ээс илүүгүй байхаар тогтоож, ажлын хоногт дунджаар 40 км-ээс тус тус хэтрүүлэхгүй хэрэглэж байхаар тогтоосугай", 8-т "Төсвөөс санхүүждэг байгууллага хот дотор ажил, үйлчилгээнд хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж нь 2500 см<sup>3</sup>-ээс дээш, туулах чадвар өндөртэй, шатахуун их зарцуулдаг автомашин хэрэглэх, бүх шатны байгууллага, албан тушаалтан эрхлэх асуудлын хүрээний болон харьяа байгууллагаас автомашин гаргуулан хэрэглэх, шатахууны зардлыг төлүүлэхийг тус тус хориглосугай" гэсэн заалтуудтай нийцэхгүй, үнэн зөв байдал, хэмжилт, тохиолдсон байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### 3.2 Эрсдэл:

Төсвийг хэмнэлтгүй зарцуулах, зардал өсөх болон санхүүгийн үр дүн буурах

### 3.3 Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсөвт зардлыг хэтрүүлэн зарцуулахгүй, албан ажлын хэрэгцээний автомашины хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж 2500 см<sup>3</sup>-ээс дээш, туулах чадвар өндөртэй, шатахуун их зарцуулдаг автомашин ашиглахгүй байх

### 3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчлийг байгууллагын дарга, нягтлан бодогч нар хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4.Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>545,185,740.16</b>	<b>514,422,059.42</b>
<b>31</b>	<b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b>	83.20	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	83.20	-
3121	Төгрөг	83.20	-
31211	Төрийн сангийн харилцах	(0.00)	-
31213	Арилжааны банкин дахь харилцах	83.20	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>263,778,584.36</b>	<b>209,511,298.96</b>
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	13,648,485.10	13,125,420.59
335	Бусад авлага	250,130,099.26	196,385,878.37
3351	Байгууллагаас авах авлага	244,959,095.26	191,277,374.37
3352	Хувь хүмүүсээс авах авлага	5,171,004.00	5,108,504.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>281,407,072.60</b>	<b>304,910,760.46</b>
351	Түүхий эд материал	166,991,094.86	155,497,098.25
35130	Эм боох материал	166,991,094.86	155,497,098.25
354	Хангамжийн материал	114,415,977.74	149,413,662.21
35410	Бичиг хэргийн материал	13,642,815.00	24,306,427.50
35420	Аж ахуйн материал	27,836,935.00	37,468,422.00
35430	Сэлбэг хэрэгсэл	11,919,800.00	12,359,800.00
35470	Бусад хангамжийн материал	61,016,427.74	75,279,012.71
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,682,159,794.07</b>	<b>2,558,772,811.50</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,682,159,794.07</b>	<b>2,558,772,811.50</b>
392	Биет хөрөнгө	2,553,534,807.42	2,441,781,158.27
39201	Барилга, байгууламж	3,039,461,171.00	3,039,461,171.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(937,867,333.88)	(2,914,442,804.04)
39203	Авто тээврийн хэрэгсэл	176,900,000.00	176,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(144,545,833.08)	(349,183,332.72)
39205	Машин, тоног төхөөрөмж	1,000,370,799.44	1,011,530,799.44
39206	Хуримтлагдсан элэгдэл	(655,051,757.18)	(705,987,700.62)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	164,308,871.52	164,308,871.52
39208	Хуримтлагдсан элэгдэл	(92,189,260.40)	(100,416,782.03)
39214	Бусад үндсэн хөрөнгө	990,000.00	990,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(305,250.00)	(396,000.00)
39217	Номын фонд	1,463,400.00	1,463,400.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>128,624,986.65</b>	<b>116,991,653.23</b>
39301	Програм хангамж	131,220,000.00	131,220,000.00
39302	Хасагдуулга	(50,478,333.35)	(62,111,666.77)
39303	Бусад биет бус хөрөнгө	47,883,320.00	47,883,320.00

<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>3,227,345,534.23</u></b>	<b><u>3,073,194,870.92</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b><u>259,491,028.91</u></b>	<b><u>179,074,590.99</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>259,491,028.91</u></b>	<b><u>179,074,590.99</u></b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	246,390,228.91	141,077,890.99
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	15,934,032.59	49,999.99
4136	Бусад өглөг	230,456,196.32	141,027,891.00
